

САНАЛЫН ТОВЪЁОГ

“Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж 21-ний өдрийг дуустал саналуудыг цахимаар хүлээн авав.

Дээрхи ажлын хүрээнд дараах саналуудыг ирүүлсэн байна.

№	Журмын төсөлд ирүүлсэн санал	Саналын агуулга	Санал гаргасан байгууллага	Тайлбар
1	<p>Хоёр.Чөлөөт бүсэд зорчигчийг нэвтрүүлэх</p> <p>Төслийн 2.2.1 дэх заалтыг “Монгол Улсын иргэн үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх түүнийг орлох баримт бичиг” гэж өөрчлөн найруулах.</p> <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтад "цахим баримт бичиг" гэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.9-д заасныг”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт “Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон давтагдашгүй дугаар бүхий цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.” гэж заасан.</p>	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	
2	<p>Хоёр.Чөлөөт бүсэд зорчигчийг нэвтрүүлэх</p> <p>Төслийн 2.2.2 дахь заалтыг “Гадаадын иргэн паспорт, түүнийг орлох баримт бичиг” гэж өөрчлөн найруулах.</p> <p>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9. дэх заалтад "паспорт" гэж олон улсын эрх бүхий</p>	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	

	байгууллага, түүнчлэн гадаад улсын болон Монгол Улсын Засгийн газраас олгосон буюу хүлээн зөвшөөрсөн олон улсад зорчих баримт бичгийг, 5.1.10 дахь заалтад "паспортыг орлох баримт бичиг" гэж Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр паспорттай адилтган үзэхээр хүлээн зөвшөөрсөн, тухайн хүнийг гадаад улсын иргэн болохыг гэрчилж байгаа баримт бичгийг хэлнэ гэж заасан. Мөн Засгийн газрын 2021 оны 194 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын иргэн Монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам"-д заасны дагуу хуулийн үг хэллэгт нийцүүлэх.			
3	Хоёр.Чөлөөт бүсэд зорчигчийг нэвтрүүлэх Төслийн 2.2.3 дахь заалтыг "Монгол Улсын 16 насанд хүрээгүй иргэн төрсний гэрчилгээ, үндэсний гадаад паспорт, түүнийг орлох баримт бичиг" гэж өөрчлөн найруулах.	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	
4	Гурав. Чөлөөт бүсэд бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх Төслийн 3.2.1.1 дэх заалтыг "Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт түүнийг орлох бичиг баримт, эсхүл хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэх" гэж өөрчлөн найруулах. Засгийн газрын 2016 оны 126 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам", Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/394 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	

	бүртгэлийн байгууллагаас үндэсний энгийн гадаад паспорт, хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох, гадаадад зорчих эрхийн бүртгэл хөтлөх журам"-ын үг хэллэгт нийцүүлэх.			
5	Гурав. Чөлөөт бүсэд бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх Төслийн 3.2.2.1 дэх заалтыг “ паспорт, түүнийг орлох баримт бичиг, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэх ” гэж өөрчлөн найруулах.	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	
6	Зургаа. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалт Төслийн 6.1.1.3 дахь заалтын “ ... хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг орлох баримт бичиг ” гэж өөрчлөн найруулах. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтад "цахим баримт бичиг" гэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.9-д заасныг", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт “Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон давтагдашгүй дугаар бүхий цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.” гэж заасан.	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	
7	Зургаа. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалт Төслийн 6.4 дэх хэсгийн “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны	Өөрчлөн найруулах		

	<p>байгууллага нь чөлөөт бүсээс олгосон бүртгэлийн гэрчилгээ, шийдвэрийг үндэслэж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт оруулна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 7 хоногт Захирагчийн ажлын албанд ирүүлнэ.” гэсний “... Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 7 хоногт Захирагчийн ажлын албанд ирүүлнэ.” гэснийг 6.5 дахь хэсэг болгож “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн хуулийн этгээд нь нэмэлт оруулсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 7 хоногт Захирагчийн ажлын албанд ирүүлнэ” гэж өөрчлөн найруулах.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 7 хоногт Захирагчийн ажлын албанд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн аль субъект нь хүргүүлэх талаар тодорхойгүй байна.</p>		Улсын бүртгэлийн ерөнхий газар	
8	<p>Долоо. Иргэн, хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах</p> <p>Төслийн 7.2 дахь хэсгийн “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх ...” гэснийг “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа...” гэж өөрчлөн найруулах;</p> <p>Чөлөөт бүсийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгтэй уялдуулах, мөн ирээдүйд үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг</p>	Өөрчлөн найруулах	Улсын бүртгэлийн ерөнхий газар	

	бүртгэлээс хасах боломжгүй, “эрхлэх” гэсэн үг нь хоёрдмол утга илэрхийлж байна.			
9	Хоёр.Чөлөөт бүсэд зорчигчийг нэвтрүүлэх Төслийн 2.6. Байнгын болон түр нэвтрэх үнэмлэхтэй этгээд нь чөлөөт бүсээс гарахдаа гаалийн хяналт шалгалтад хамрагдана. Гэснийг ... хилийн болон гаалийн хяналт шалгалтад хамрагдана. Гэж өөрчлөн найруулах;	Өөрчлөн найруулах	Хил хамгаалах ерөнхий газар	
10	Гурав. Чөлөөт бүсэд бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх Төслийн гуравт 3.5. Бүсийн ажиллах цагийн хуваарийг тогтоож өгөх. гэж нэмэлт оруулах;	Нэмэх	Хил хамгаалах ерөнхий газар	
11	Гурав. Чөлөөт бүсэд бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх Төслийн гуравт 3.6. Бүсэд нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүний хяналт шалгалт хийж буй байгууллагуудын харилцан ажиллагааг /хилийн болон гаалийн хяналт шалгалтад хамрагдсан эсэхийг харилцан мэддэг байхаар/ тодорхой зааж өгөх.	Нэмэх	Хил хамгаалах ерөнхий газар	Хэлэлцүүлгийн үеэр нэгдсэн ойлголттой болж мэдээлэл солилцох, программаар зохицуулах
12	Найм. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт Төслийн 8.2.1. Хилийн зурваст байгуулагдсан чөлөөт бүсийн харуул хамгаалалт, зорчигч тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн	Өөрчлөн найруулах	Хил хамгаалах ерөнхий газар	

	харуул хамгаалалтын үүргийг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ. гэж өөрчлөн найруулах.			
13	<p>Найм. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт</p> <p>Төслийн 8-т “8.2.3. Хилийн зөрчлийн мэдээлэл авагдсан, шинж тэмдэг илэрсэн үед цаг хугацааг харгалзахгүйгээр Хил хамгаалах байгууллага хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хилийн эрлийг явуулах.” гэж нэмэх;</p>	Нэмэх	Хил хамгаалах ерөнхий газар	
14	<p>Арав. Чөлөөт бүс дэх бусад үйлчилгээний зохицуулалт</p> <p>Төслийн 10.5. “Гамшиг осол, хүн малын гоц халдварт өвчин гарч Онцгой байдлын зэрэгт шилжүүлсэн тохиолдолд ажиллах төлөвлөгөөтэй /байгууллага бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсон/ байх, тухайн тогтоосон дэглэмийг баримтлан ажиллана.” Гэж өөрчлөн найруулах;</p>	Өөрчлөн найруулах	Хил хамгаалах ерөнхий газар	
15	<p>Дөрөв. Чөлөөт бүсээс барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах</p> <p>Төслийн 4.1-4.3 дахь хэсгийг хасах</p> <p>4.1. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдаж авсан Чөлөөт бүсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтад заасан үнийн дүнтэй Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Барааны нэр, төрлийн жагсаалт”-д тусгасан барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.</p>	Хасах	Гаалийн ерөнхий газар	

	<p>4.2. Энэхүү журмын 4.1-д заасан үнийн дүнтэй барааг зорчигч хоногт нэгээс илүүгүй удаа чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад барааны нэр төрөл, тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй бөгөөд нэг удаагийн худалдан авсан барааны үнийн дүн нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд үнийн зөрүүд ногдох татварыг зохих журмын дагуу ногдуулна.</p> <p>4.3. Энэхүү журмын 4.1-д заасан барааны үнийн дүнд согтууруулах ундаа, тамхи, эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн хамаарахгүй. Гэснийг тус тус хасах;</p>			
16	<p>Дөрөв. Чөлөөт бүсээс барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах</p> <p>Төслийн 4.5. “Хөрш улстай хэлэлцээрийн дагуу байгуулсан бүс хооронд барааг хилийн гарцаар нэвтрүүлэхэд гаалийн байгууллага эрсдэлд суурилсан хялбарчилсан хяналт тавина.”-гэснийг өөрчлөн найруулах;</p>	Өөрчлөн найруулах	Гаалийн ерөнхий газар	
17	<p>Долоо. Иргэн, хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах</p> <p>Төслийн 7.2. “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг дараах үндэслэлээр чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасна:” “Гаалийн хууль тогтоомжийг жилд хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн” нэмэх;</p>	Нэмэх	Гаалийн ерөнхий газар	Чөлөөт бүсийн тухай хуульд тусгагдаагүй заалт тул хүлээж авах боломжгүй. Тусгай зөвшөөрлийн журамд оруулах боломжтой.
18	<p>Найм. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт</p> <p>Төслийн 8.3.1 “Чөлөөт бүсэд бараа оруулах, гаргах, боловсруулалт хийх үйл ажиллагаа</p>	Өөрчлөн найруулах	Гаалийн ерөнхий газар	

	<p>бүхэлдээ гаалийн хяналтад байна” гэж өөрчлөн найруулах;</p>			
19	<p>Найм. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт</p> <p>Төслийн 8.3.4. Чөлөөт бүсээс хилийн чанадад гаргаж буй бараа, бүтээгдэхүүнд татвар ногдуулахгүй зөвхөн гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ; “Барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ” гэж засах;</p>	Өөрчлөн найруулах	Гаалийн ерөнхий газар	
20	<p>Найм. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт</p> <p>Төслийн 8.4. “Чөлөөт бүс дэх Мэргэжлийн хяналтын зохицуулалт” хасах.</p> <p>/2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн дагуу хилийн мэргэжлийн хяналтын чиг үүрэг гаалийн байгууллагад шилжсэн тул төслийн 8.4 дэх хэсгийг хасаж, төслийн “ гурав. “Чөлөөт бүсэд бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн бүлэгт 8.4.1-8.4.3 дахь заалтуудыг нэмэх;</p> <p>8.4.1 Чөлөөт бүсийн гарцаар нэвтрүүлж буй зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараагаар дамжин Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг хүний хөл хорио халдварт өвчин болон мал, амьтны олон улсад шуурхай болон тогтмол мэдээлэх халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх хяналт хийх, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	Өөрчлөн найруулах	Гаалийн ерөнхий газар	

<p>8.4.2 Чөлөөт бүс дэх бараа, бүтээгдэхүүнд хүнс, химийн гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан үед болон байгаль орчны бохирдолтой холбоотой гомдол, мэдээлэл ирсэн нөхцөлд хяналт хийх;</p> <p>8.4.3. Чөлөөт бүсэд хүн, малын гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үед болон хорио цээрийн дэглэм тогтоосон үед хийгдэх ариутгал, халдваргүйжүүлэх үйл ажиллагааны чанарт хяналт тавих;</p>			
--	--	--	--